

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БОЛОН
БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ШИЙДВЭРИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА**

*/Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны
эрхлэх асуудлын хүрээнд/*

2018.07.27

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаархи тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийж, ирүүлсэн санал дээр үндэслэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд гаргасан хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг хавсарган хүргүүлж байна.

“Монгол Улсын Засгийн газарт хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн 2017 оны жилийн эцсийн хэрэгжилтийн танилцуулга”-ыг Улсын Их Хурлын www.parliament.mn цахим сүлжээнд байршуулсан болно.

**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ХУУЛИАР ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ЗАСГИЙН
ГАЗРЫН ГИШҮҮДЭД ТУСГАЙЛАН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛ ӨГСӨН ЗААЛТЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР**

2.1. Монгол Улсын хуулийн хэрэгжилт

Улсын Их Хурлын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс 2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд хууль хэрэгжүүлэхтэй нийцүүлэн холбогдох дүрэм, журам, жагсаалтыг батлан гаргах үүрэг өгсөн Монгол Улсын 70 хуулийн 392 хэсэг, заалтыг мэдээллийн санд бүртгэж, хяналтад авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 78 хуулийн 197 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс, хяналтад байгаа 26 хууль буюу 33.3 хувь, 105 хэсэг, заалт буюу 26.7 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 56 /давхардсан тоогоор/ хуулийн 287 хэсэг, заалт буюу 73.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Мөн 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 14 хуулийн 18 хэсэг, заалтыг хяналтаас хассан тухай мэдээг ирүүлж, өмнөх онуудад хяналтаас хасагдсан 49 хуулийн 74 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

		Хууль	Хэсэг, заалт
1	2017 оны жилийн эцсийн байдлаар хяналтанд авсан	70	392
2	Засгийн газраас ирүүлсэн Үүнээс:	78	197
-	Хяналтанд байгаа	26	105

-	Өмнөх онуудад бүрэн хэрэгжиж хяналтаас хассан	49	74
-	2017 оны хагас жилээр хяналтаас хасагдсан	14	18
3	Засгийн газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	56	287

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 26 хуулийн 105 хэсэг, заалтаас 13 хуулийн 23 хэсэг, заалт буюу 21.9 хувь нь бүрэн хэрэгжсэн, 8 хуулийн 11 хэсэг, заалт буюу 10.5 хувь нь хэрэгжих шатанд, 23 хуулийн 58 хэсэг, заалт буюу 55.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 хуулийн 1 хэсэг, заалт буюу 1.0 хувь нь хэрэгжээгүй, 4 хуулийн 12 хэсэг, заалт буюу 11.4 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

2.2. Монгол Улсын хуулиар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар болон Засгийн газрын гишүүдэд тусгайлан үүрэг өгсөн заалтын хэрэгжилт

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг өгсөн Монгол Улсын 13 хуулийн 75 хэсэг, заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар нийт 7 хуулийн 45 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн бөгөөд давхардсан тоогоор 13 хуулийн 30 хэсэг, заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн хуулийн хэрэгжилтийн явцыг авч үзвэл, давхардсан тоогоор 4 хуулийн 7 хэсэг, заалт буюу 15.6 хувь нь бүрэн хэрэгжсэн, 3 хуулийн 6 хэсэг, заалт буюу 13.3 хувь нь хэрэгжих шатандаа, 5 хуулийн 29 хэсэг, заалт буюу 64.4 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 хуулийн 3 хэсэг, заалт буюу 6.6 хувь нь хэрэгжээгүй байна.

	Хууль	Хэсэг, заалт	
	/давхардсан тоогоор/	Тоо	Хувь
Хяналтанд авсан	13	75	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	7	45	60.0
Үүнээс:			
- бүрэн хэрэгжсэн	4	7	15.6
- хэрэгжих шатандаа	2	6	13.3
- хэрэгжилт хангалтгүй	5	29	64.4
- хэрэгжээгүй	1	3	6.7
Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй /давхардсан тоогоор/	13	30	40.0

2.3. Мэдээнд гарсан зөрчил

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн хуулийн хэрэгжилтийн мэдээнд 2012-2016 онуудад бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хассан хуулийн заалтыг дахин ирүүлсэн, мөн 2016 оны жилийн эцсийн хэрэгжилтийн мэдээнд 50-70 хувьтай хэрэгжиж байсан 6 хуулийн 17 заалтын хэрэгжилтийн хувь хэмжээг бууруулан 10-30 хувь буюу “хэрэгжилт хангалтгүй” гэж үнэлэн, хэрэгжилтийг бууруулан ирүүлсэн байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг өгсөн нийт 70 тогтоолын 171 заалтыг хяналтад авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 45 тогтоолын 106 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлснээс, хяналтад байгаа 20 тогтоолын 48 заалт буюу 28.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 57 /давхардсан тоогоор/ тогтоолын 123 заалт буюу 72.0 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 17 тогтоолын 27 заалт, 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 22 тогтоолын 31 заалтыг хяналтаас хассан тухай мэдээг дахин ирүүлсэн байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 20 тогтоолын 48 заалтаас 11 тогтоолын 18 заалт буюу 37.5 хувь нь бүрэн хэрэгжсэн, 10 тогтоолын 22 заалт буюу 45.8 хувь нь хэрэгжих шатанд, 3 тогтоолын 3 заалт буюу 6.2 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 2 тогтоолын 2 заалт буюу 4.3 хувь нь хэрэгжээгүй, 3 тогтоолын 3 заалт буюу 6.2 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

3.2. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилт

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Улсын Их Хурлын 8 тогтоолын 24 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналтанд авсан.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын нийт 6 тогтоолын 11 заалтын хэрэгжилтийг ирүүлсэнээс мэдээллийн сангийн хяналт байгаа 3 тогтоолын 7 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 5 тогтоолын 17 заалтын мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг авч үзвэл давхардсан тоогоор 1 тогтоолын 1 заалт буюу 14.3 хувь нь бүрэн хэрэгжсэн, 3 тогтоолын 5 заалт буюу 71.4 хувь нь хэрэгжих шатанд, 1 тогтоолын 1 заалт буюу 14.3 хувь нь хэрэгжилт хангалтгүй байна.

	УИХ-ын тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
Хяналтанд авсан	8	24	100.0
Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн	3	7	29.2
Үүнээс:			
- Хэрэгжсэн	1	1	14.3
- Хэрэгжих шатанд байгаа	3	5	71.4
- Хэрэгжилт хангалтгүй	1	1	14.3
Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй	5	17	70.8

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Улсын Их Хурлын тогтоолын биелэлтийг ирүүлэхдээ 2012-2017 оны эхний хагас жилд бүрэн хэрэгжиж, хяналтаас хассан 3 тогтоолын 6 заалтыг ирүүлсэн бөгөөд дараах хяналтанд байгаа тогтоолуудын хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна. Үүнд:

№	Тогтоолын нэр, огноо	Заалт	Заалтын агуулга
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2013.02.07 №19	1.1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт оношлох, нийгэмшүүлэх, хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй гэр бүлд нийгмийн хамгааллын, эрүүл мэндийн сэргээн засах үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлыг судлан үзэж холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
		1.2	хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсролын үйлчилгээг тусгай сургууль болон сэргээн засалтын бусад төрөлжсөн байгууллага эзэмшүүлэх ажлыг шинэчлэн зохион байгуулах;
		1.3	хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах чиглэлээр мэргэших дохионы хэлний багш, арга зүйч, эмч, согог зүйч зэргийг бэлтгэх зорилгоор нийт 20-оос доошгүй хүнийг жил бүр гэрээгээр, сургалтын төрийн сангийн зардлаар гадаадад сургах арга хэмжээ авах.
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 2013.02.07 №20	1.1	Улсын Их Хурлын даргын 2012 оны 103 дугаар захирамжаар байгуулсан барилгын тухай, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсгийн тайлан, дүгнэлтийг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон барилгын тухай хууль тогтоомж, стандарт, норм ба дүрэм зөрчсөн, түүнчлэн зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан аж ахуйн нэгж, байгууллага, холбогдох этгээдийг нийтэд мэдээлэх, тэдгээрт хариуцлага тооцох;
		1.2	барилгын ажил эрхлэх аливаа зөвшөөрөл /техникийн нөхцөл, дүгнэлт зэрэг/, тусгай зөвшөөрөл олгосон байдал, түүнчлэн хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, нэгдсэн эмнэлгийн эдэлбэр газарт барилга байгууламж барих зөвшөөрөл олгосон асуудлыг хууль, хяналтын байгууллагын оролцоотой ажлын хэсэг байгуулан шалгаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах;
		1.3	барилгын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичгийн тоог цөөрүүлж, тусгай зөвшөөрөл олгох асуудлыг нэг цэгийн үйлчилгээнд шилжүүлэх;
		1.5	хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж зөрчигдсөний улмаас эрүүл мэндээрээ хохирсон иргэн болон амь насаа алдсан иргэний гэр бүлд нөхөн төлбөр олгох асуудалтай холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
		1.8	аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын таван хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд зарцуулах чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
		1.10	хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг олон улс, бүс нутгийн түвшинд хүргэж шинэчлэх, санхүүжилтийн асуудлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх;
		1.12	мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох, эрт илрүүлэх зорилгоор Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, эмч, эрүүл ахуйн ажилтныг бэлтгэх, тэдний чадавхийг дээшлүүлэх

			ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;
		1.13	хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын байран дахь сургалт, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, түүнчлэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, осолгүй ажилласан аж ахуйн нэгж, байгууллагыг нийтэд мэдээлэх.
3	Монгол судлалыг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2014.01.16 №17	1.1	монгол судлалыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Монгол судлалын үндэсний зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд байгуулан ажиллуулах;
		1.2	Монголын түүх, нийгэм, соёл, хэл, зан заншил, үндэсний баялаг өв сангаа судлах, хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэх, хилийн чанадад болон дотоодод монгол судлалыг тогтвортой хөгжүүлэхэд Монгол судлалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг чиглүүлж, холбогдох дүрэм, журмыг боловсруулан баталж мөрдүүлэх;
		1.3	Монгол судлалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг Монгол судлалыг дэмжих сангийн чиг үүрэгтэй уялдуулж, Засгийн газрын 2012 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 56 дугаар тогтоолоор баталсан “Монгол судлалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах;
		1.4	Монгол судлалыг дэмжих сангийн хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт бүрэн тусгаж байх.
4	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлах тухай 2015.01.29 №29	2.1	“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэхтэй уялдуулан холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлаар батлуулан хэрэгжүүлэх;
5	“Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай” 2017.06.02 №40	3	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрмийг боловсруулж, Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулганы хугацаанд багтаан Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд ирүүлэхийг Үндэсний зөвлөл /Н.Номтойбаяр/-д даалгасугай.
Нийт 5 тогтоолын 17 заалт			

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛЫН ТАЛААР

4.1. Байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд 2017 оны жилийн эцсийн байдлаар Улсын Их Хурлын Байнгын хорооноос Засгийн газарт үүрэг өгсөн нийт 100 тогтоолын 544 заалтыг хяналтанд авсан.

2017 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 46 тогтоолын 186 заалтын хэрэгжилтийн мэдээ ирүүлсэнээс, хяналтанд байгаа 36 тогтоолын 124 заалт буюу 22.8 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 81 /давхардсан тоогоор/ тогтоолын 420 заалт буюу 77.2 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн 36 тогтоолын 124 заалтаас 18 тогтоолын 41 заалт буюу 33 хувь нь бүрэн хэрэгжсэн, 21 тогтоолын 53 заалт буюу 42.7 хувь нь хэрэгжих шатанд, 14 тогтоолын 23 заалт буюу 18.5 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 1 заалт буюу 0.8 хувь нь хэрэгжээгүй, 5 тогтоолын 6 заалт буюу 5 хувь нь үнэлэх боломжгүй мэдээ ирүүлсэн байна.

Мөн өмнөх онуудад хяналтаас хасагдсан 13 тогтоолын 29 заалт, 2017 оны эхний хагас жилээр хяналтаас хасах саналтай хүргүүлсэн 22 тогтоолын 33 заалтын хэрэгжилтийн мэдээг дахин ирүүлсэн байна.

4.2. Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны тогтоолын хэрэгжилт

Засгийн газарт үүрэг өгсөн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 16 тогтоолын 121 заалтыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэдээллийн санд бүртгэж хяналт тавин ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2017 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 6 тогтоолын 36 заалтын хэрэгжилтийн мэдээг ирүүлж, 14 тогтоолын 85 заалт буюу 70.2 хувийнх нь хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

Хэрэгжилтийн мэдээг ирүүлсэн тогтоолын хэрэгжилтийн явцыг авч үзвэл, давхардсан тоогоор 3 тогтоолын 8 заалт буюу 22.2 хувь нь бүрэн хэрэгжсэн, 5 тогтоолын 9 заалт буюу 25.0 хувь нь хэрэгжих шатандаа, 5 тогтоолын 13 заалт буюу 36.1 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 1 тогтоолын 4 заалт буюу 11.1 хувь хэрэгжээгүй, 1 тогтоолын 2 заалт буюу 5.6 хувь хүчингүй болсон байна.

	НББСШУБХ-ны тогтоол /давхардсан тоогоор/	Заалт	
		Тоо	Хувь
<i>Хяналтанд авсан</i>	16	121	100.0
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй</i>	14	85	70.2
<i>Хэрэгжилтийн мэдээ ирүүлсэн</i>	6	36	29.8
<i>Үүнээс:</i>			
- <i>Хэрэгжсэн</i>	3	8	22.2
- <i>Хэрэгжих шатанд</i>	5	9	25.0
- <i>Хэрэгжилт хангалтгүй</i>	5	13	36.1
- <i>Хэрэгжээгүй</i>	1	4	11.1
- <i>Хүчингүй болсон</i>	1	2	5.6

4.3. Хэрэгжилтийн мэдээ ирүүлээгүй

1. “Нийслэлийн Улаанбаатар хотын утаа, агаарын бохирдолтыг багасгах арга хэмжээний талаар” Төсвийн байнгын хороотой хамтран баталсан 2010 оны 01/03 дугаар тогтоолын 2 дахь заалт;
2. “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2010 оны 15 дугаар тогтоолын 1.1, 1.2, 1.3, 2.1, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7 дахь заалт;
3. “Нийслэлийн амаржих газруудын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд авах арга хэмжээний тухай” 2010 оны 07 дугаар тогтоолын 3 дахь заалт;
4. “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2012 оны 09 дүгээр тогтоолын 8 дахь заалт;
5. “Сургалтын төрийн сангийн зээлийн ашиглалт, төлөлт, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай 2013 оны 04/04 дүгээр тогтоолын 1.4, 1.5 дахь заалт;

6. “Шинжлэх ухааны байгууллагуудыг бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2014 оны 07 дугаар тогтоолын 1.9 дэх заалт;
7. “Эмнэлгийн барилга, эзэмшил газрын талаар цаашид авах арга хэмжээний тухай” 2014 оны 09 дүгээр тогтоолын 1.5, 1.6, 2 дахь заалт;
8. “Эбола вируст халдвараас урьдчилан сэргийлэх тухай” 2014 оны 13 дугаар тогтоолын 1, 2, 3, 4 дэх заалт;
9. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2016 оны 09/03 дугаар тогтоолын 1.16, 1.17 дахь заалт;
10. “Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай” 2016 оны 10 дугаар тогтоолын 13.1, 3.2 дахь заалт;
11. “Шинжлэх ухаан, технологийн салбарын үйл ажиллагааг дэмжих зарим арга хэмжээний тухай” 2017 оны 17 дугаар тогтоолын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 1.10, 2 дахь заалт;
12. “Инновацийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2017 оны 18 дугаар тогтоолын 2.1, 2.2, 2.3, 2.4, 3.1, 3.2, 3.3, 3.5, 3.6, 3.7, 4, 5, 6, 7, 8 дахь заалт;
13. “Эрүүл мэндийн бодлого, эрүүл мэндийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, цаашид авах арга хэмжээний тухай” 2017 оны 22 дугаар тогтоолын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 1.10, 1.11, 1.12, 1.13, 2, 3 дахь заалт;
14. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2017 оны 24 дүгээр тогтоолын 1.1, 1.2, 1.3, 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 1.10, 1.11, 1.12, 1.13, 1.14, 1.15, 2, 3 дахь заалт зэрэг болно.

4.4. Мэдээнд гарсан зөрчил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас “Сургалтын төрийн сангийн зээлийн ашиглалт, төлөлт, төсвийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 2013 оны 04/04 дүгээр тогтоолын 1.9 дэх заалтыг дахин ирүүлсэн бөгөөд НББСШУБХ-ноос 2016-2017 онд Засгийн газарт чиглэл өгсөн тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээг ирүүлээгүй байна.

ТАВ. БҮРЭН БИЕЛСЭН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗҮЙЛ ЗААЛТЫГ ХЯНАЛТААС ХАСАХ ТУХАЙ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээн дэх хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжсэн Монгол Улсын 4 хуулийн 7 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 1 тогтоолын 1 заалт, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 4 тогтоолын 6 заалтыг хууль тогтоомжийг хяналтаас хасах саналыг ирүүлсэнг хавсралтаар хүргүүлж байна.

ЗУРГАА. САНАЛ

1/ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн хэрэгжилтийг тооцохдоо хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцөлийг тодруулж тайлбарлаагүй орхигдуулсан, хяналтанд байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн ирүүлээгүй байна. Тухайлбал, тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн Монгол Улсын 13 хуулийн 30 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 5 тогтоолын 17 заалт, Байнгын хорооны 14 тогтоолын

85 заал буюу хяналтанд авсан дийлэнх хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй байна.

2/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийг ирүүлэхдээ хэрэгжилт удаашралтай байгаа заалтуудын биелэлтийг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах, хариуцсан яамд, агентлагуудад хариуцлага тооцдоггүй байдал нь хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

3/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээнд бүрэн хэрэгжиж, хяналтаас хасах санал ирүүлж, холбогдох Байнгын хороонд танилцуулсан хууль тогтоомжийн заалтыг дахин ирүүлэх, мэдээллийн санг шинэчлэхгүй байх, өмнө ирүүлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь хэмжээг бууруулан дахин ирүүлэх, шинээр хяналтанд авсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг ирүүлэхгүй байх зэрэг дутагдалтай байна.

4/ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг хагас жил тутам ирүүлэхдээ хугацааны хувьд удаашралтай, 3-4 сарын дараа ирүүлж байгаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороонд хүргүүлэхэд хэрэгжилтийн мэдээний ач холбогдолыг бууруулах, хууль тогтоомж бүрэн хэрэгжихэд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

**НИЙГМИЙН БОДЛОГО БОЛОВСРОЛ,СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНД ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ХУУЛИЙН ЖАГСААЛТ
/2017 оны жилийн эцсийн байдлаар/**

№	Хуулийн нэр, огноо	Агуулга	Хэрэгжилт
1	Эмнэлэгийн тусламж, үйлчилгээний тухай 2016.04.22	15.29.Нэр дэвшүүлэн сонгох хурлыг зохион байгуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Журам батлах тухай” А/189 дугаар тушаал, 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” А/209 дүгээр тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэгийн төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг сонгох журмыг баталсан.
2	Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/ 2015.01.29	16.3. Энэ хуулийн 16.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг Засгийн газар батална. <i>/16.2. Төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг худалдан авах ажиллагааг эрүүл мэндийн даатгалын байгууллага гэрээний үндсэн дээр үе шаттайгаар гүйцэтгэнэ./</i>	Засгийн газрын "Төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн зарим тусламж, үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааны журам батлах тухай" 2017 оны 156 дугаар тогтоолоор баталсан. Уг журам батлагдсанаар хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үзүүлэх тусламж, үйлчилгээг нийгмийн даатгалын байгууллагаар дамжуулан төр худалдан авах, улсын эмнэлгийн ачааллыг бууруулах, улмаар төр төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээ иргэд, даатгуулагчид хүртээмжтэй хүргэх, чанар үр дүнд хяналт тавих нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.
3	Эрүүл ахуйн тухай 2016.02.04	4.2.Энэ хуулийн 4.1.5-д заасан эрсдэлийн үнэлгээ хийх зааврыг эрүүл мэндийн болон барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. <i>/4.1.5.-т Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээг тогтмол хийлгэх, гарсан үнэлгээний дагуу арга хэмжээг авах үүргийг тухайн шатны Засаг дарга хүлээх./</i>	Энэ хуулийн 4.1.5-д заасан Ариун цэврийн байгууламжийн эрсдэлийн үнэлгээ хийх зааврыг боловсруулах ажлын хэсгийн хурлаар 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдөр төслийг хэлэлцүүлсэн. Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх зааврыг Эрүүл мэнд, Барилга, хот байгуулалтын сайдын 2017.04.17-ны өдрийн А/149-78 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан. Жижиг суурин газарт эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг Эрүүл ахуйн тухай хуулийн 16.2.5-ыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2017.04.17-ны өдрийн А/150 дугаар тушаалаар батлуулсан.
		7.6.Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах журам”-ын төслийг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн А/145 дугаар тушаалаар баталсан ба журмын дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2017 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 3718 дугаарт бүртгүүлсэн.

4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай 2016.02.05	9.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй буюу түүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн орчны болон дотоод зохион байгуулалтын заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилгын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.	Тус стандартыг Стандарт хэмжил зүйн үндэсний зөвлөлийн 2009 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталж, заавал мөрдөхөөр заасан.
		37.7. Энэ хуулийн 37.2.2-т заасан хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тодорхойлох аргачлалыг эрүүл мэнд, хөдөлмөр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. <i>/37.2.2-т 16 ба түүнээс дээш насны хүний хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс/</i>	Даатгуулагч (иргэн)-ийн хөдөрмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт, хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай журмыг шинээр боловсруулж, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2017 оны А/39 А/12 тушаалаар баталсан.
		38.4.Энэ хуулийн 38.1-д заасан үнэмлэхийн загвар, түүнийг олгох журмыг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. <i>/38.1.Энэ хуулийн 37.2-т заасан комиссын дүгнэлтийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бүртгэн үнэмлэх олгох үүргийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ./</i>	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 38.4-т заасан Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/109 тоот тушаалаар баталсан.
Нийт 4 хуулийн 7 хэсэг, заалтыг хяналтаас хасах саналыг ирүүлсэн байна			

**НИЙГМИЙН БОДЛОГО БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНД ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	Төрөөс тэтгэвэрийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай 2015.06.16 №53	5.1.“Төрөөс тэтгэвэрийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого”-ын зорилго, зарчимд нийцүүлэн холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/244 дүгээр тушаалаар Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл, хуулийн үзэл баримтлалын төсөл, танилцуулга боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ХНХЯ, СЯ, ХЗЯ, ЭМНДЕГ, НДҮЗ-ийн ажлын алба, МХЕГ, АОЭНХ, МҮЭХ, Аймаг, дүүргийн НДХ-ийн төлөөллүүд ажиллаж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж, бусад 6 хуулийн эхний төслийг боловсруулаад байна. Түүнчлэн НД-ын багцад хамаарах Нийгмийн даатгалын ерөнхий хууль, НДС-аас олгох тэтгэвэрийн тухай, НДС-аас олгох тэтгэмжийн тухай, НДС-аас олгох ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нэрийн дансны аргаар бодох өндөр насны тэтгэвэрийн тухай зэрэг хуулиудын эхний төслийг бүх бүсэд болон Нийслэлийн хэмжээнд хэлэлцүүлж, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс хуулийн төсөлд албан бичгээр санал авч, СЯ болон УИХ-ын НББСШУ-ны байнгын хорооны ажлын албаны зөвлөх, референтүүдээр хэлэлцүүлсэн. Мөн Хувийн тэтгэвэрийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулан үзэл баримтлалыг батлуулахаар СЯ болон ХЗДХ-ийн яаманд хүргүүлээд байна. Хууль тотоомжийн тухай Монгол Улсын хуулийн дагуу тандан судалгаа, үр нөлөөллийн судалгаа, зардлын тооцоог боловсруулаад байна. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 21 аймаг 9 дүүргийн хэмжээнд хэлэлцүүлээд байна. Хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүд, НББСШУ-ны Байнгын хороо, холбогдох яамд, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, иргэд, нийгмийн даатгалын шат шатны байгууллагуудыг оролцуулсан үндэсний хэлэлцүүлгийг 2016 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулж, гарсан санал зөвлөмжийг хуулийн төсөлд тусгаж ажилласан.
Нийт 1 тогтоолын 1 заалтыг хяналтаас хасах саналыг ирүүлсэн байна.			

**НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ
ХЭРЭГЖСЭН, ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛТАЙ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ**
/2017 оны жилийн эцсийн байдлаар/

№	Тогтоолын нэр, огноо, дугаар	Заалтын агуулга	Хэрэгжилт
1	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2016.03.26 №09/03	1.1.Тусгай хэрэгцээт боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн харьяаллыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяанд шилжүүлэх.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дагаж Бага, дунд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлд тусгай сургууль нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байхтай холбогдох заалт нэмж орсон. Хуулийн заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж байна.
2	Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, хязгаарлах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016.04.05 №10	1.5.Жил бүрийн хичээлийн жил эхлэхэд их, дээд сургуулийн оюутан, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг сүрьеэ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг тогтмол зохион байгуулах.	Эрүүл мэндийн сайдын 2013 оны 309 дүгээр тушаалаар 9 дүгээр сарыг “Оюутны эрүүл мэндийг дэмжих сар” болгосонтой холбогдуулан жил бүрийн хичээлийн жил эхлэхэд их, дээд сургуулийн оюутнуудыг сүрьеэ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Хөдөөгийн оюутныг эрүүл мэндийн үзлэгт цаг алдалгүй хамруулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилгоор Эрүүл мэнд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын 2016 оны А/51, А/47, А/136 дугаар тушаалаар Оюутан, суралцагчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн эрүүл мэндийн газарт үүрэг болгож, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
3	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016.12.14 №04	1.2.БЗДХ, ХДХВ/ДОХ-ын тусламж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгах, энэ чиглэлээр хэрэгжиж байгаа олон улсын байгууллагын тусламж, төсөл, хөтөлбөрийг эрчимжүүлэх.	Улсын хэмжээнд Халдварт өвчин судлалын үндэсний төв лавлагаа тусламж үзүүлж, бүх аймаг, дүүрэгт ХДХВ/ДОХ, БЗДХ-ын кабинетууд, 38 сайн дурын зөвлөгөө шинжилгээний төв ажиллаж, төрийн бус байгууллагууд зорилтот бүлгийн хүн амд тусламж үйлчилгээ үзүүлж байна. ХДХВ-ийн халдвартай иргэдийн вирусийн эсрэг эмчилгээг 2013 оноос үе шаттайгаар улсын төсөвт суулгаж 2017 оны байдлаар төрөөс 100 санхүүжүүлэн Засгийн газар НҮБ-ын Хүүхдийн сантай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу нийлүүлж байна. Эмчилгээний хамралт 85 хувьтай байна. ДОХ, Сүрьеэгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор ЭМЯ-аас бодлогын судалгааны ажлыг гэрээлэн гүйцэтгүүлсэн. Тус ажлын хүрээнд “Монгол Улс Засгийн газрын тусгай сангийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, “ДОХ, сүрьеэгийн сан” байгуулах бөгөөд хүний эрүүл мэнд, амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлдэг архи тамхины татвар буюу дотоодын архины онцгой албан татвар, импортын тамхины онцгой албан татвараас 2-3, ашигт малтмалын нөөц ашигласны, агаарын бохирдлын, хувь хүний орлогын албан татварын, байгалын нөөц ашигласны төлбөр зэргээс тус бүр 1 хувийг суутгаж, “ДОХ, сүрьеэгийн сан”-д төвлөрүүлэх замаар ДОХ, сүрьеэгийн эрүүл

			<p>мэндийн тусламжийн санхүүжилтийг үндэсний төсвөөс бүрдүүлнэ. Ингэснээр жилд 16,5 тэрбум төгрөг тус санд төвлөрнө гэсэн тооцоолол гаргаад байна. Уг асуудлыг цаашид хэрэгжүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/208 тоот тушаалаар аймгийн нэгдсэн эмнэлгийн түвшинд сүрьеэгийн оношилгоог сайжруулах зорилгоор 2017 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий, Говьсүмбэр аймгуудын Нэгдсэн эмнэлэгт Флюорографын аппарат, Архангай, Хэнтий, Төв аймгуудын Нэгдсэн эмнэлэгт Суурин рентген аппарат олгохоор баталсан.</p> <p>Сүрьеэгийн өвчлөл өндөртэй Дархан-Уул, Сэлэнгэ, Говь-Сүмбэр, Дорноговь, Завхан аймагт сүрьеэгийн эрт илрүүлгийн үзлэг зохион байгуулж, илэрсэн тохиолдлыг эмчилгээнд хамруулахаар төлөвлөсөн.</p>
		<p>1.5. Олон нийтийн радио телевизийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 Улаанбаатар хот дахь хэсэгт “олон нийтийн радио, телевизийн зорилго нь үндэсний хэмжээнд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхэлж, сонсогч, үзэгчдэд зориулсан төрөл бүрийн мэдээлэл, сургалт, танин мэдэхүй, ... Нэвтрүүлэг бэлтгэх, нийтийн хүртээл болгоход оршино” гэж заасны дагуу МҮОНРТ болон бусад хэвлэл мэдээллийн байгууллага, нийгмийн цахим мэдээллийн сүлжээг ашиглан хүн амд ХДХВ/ДОХ, БЗДХ-ын эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх тухай мэдлэг олгох сургалт, сурталчилгааг идэвхтэй зохион байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах.</p>	<p>“Мэдээлэл, сургалт сурталчилгаа зохион байгуулах тухай” Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/225 дугаар тушаал батлагдсан.</p> <p>МҮОНТВ-ийн “Амьдралын жор” нэвтрүүлэгт 2017 оны 01 сард Өсвөр насны охидын сарын тэмдгийн эрүүл ахуй ба БЗДХ-аас хамгаалах нь сэдвээр, Энд гарц байна нэвтрүүлэгт өсвөр үе, залуучуудын бэлгийн эрүүл мэнд сэдвээр, UBS телевизээр 2017 оны 2 дугаар сарын 15-нд өсвөр насныхны бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд сэдвээр, Монгол HD телевизын 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн Нүүдэл шийдэл нэвтрүүлэгт бэлгийн боловсрол ба бэлтгэлгүй ирээдүй сэдвээр, Монгол HD телевизын Наашаа цаашаа нэвтрүүлэгээр 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдөр БЗДХ, сэргийлэх талаар ярилцлага, сургалт, танин мэдэхүйн нэвтрүүлэг бэлтгэн, олон нийтийн хүртээл болгосон.</p> <p>Мөн 104.5 радиогийн Шивнээ зэрэг нэвтрүүлгээр Бэлгийн замаар дамжих халдвар, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн талаар мэдээлэл хүргэсэн.</p> <p>Глобаль сангийн сүүлийн 5 жилийн хугацаанд боловсруулан, түгээсэн ХДХВ/ДОХ-ын талаарх мэдээлэл сургалт, сурталчилгааны сан, арга зүйн материал агуулсан нийт 30 ширхэг флашын долоон ширхэгийг Улаанбаатар хотод, 15 ширхэгийг аймгуудад хуваарилан өглөө.</p> <p>2017 оны 3 сард Мэдээллийн үндэсний технологийн паркын хурлын танхимд “Эрүүл ирээдүйн төлөө хамтдаа” уриан дор мэдээллийн технологийн чиглэлээр ажилладаг байгууллага, хамт олны оролцуулсан аппликейшн бүтээх “НАСКАТОН” арга хэмжээг НҮБ-ын Хүүхдийн сан болон Канад улсын элчин сайдын дэмжлэгтэйгээр зохион байгуулсан. Тус үйл ажиллагааны хүрээнд өсвөр үеийн сэтгэц, бэлгийн болон нөхөн үржихүйн асуудлаар сэдэв тус бүр 10-15 тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар зөвлөмжийн төсөл боловсруулсан.</p> <p>"Hacking for Youth Health" хакатон тэмцээн зохион байгуулж 19 багийн 100 гаруй залуус оролцож, Pro team, IVOICE багууд шалгарсан. 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдөр -ны Б зааланд “ХДХВ, БЗХД, ДОХ-аас сэргийлэх үндэсний 7-р чуулган”-д “Өсвөр үе, хүүхэд залуучуудыг урьдчилан сэргийлэх” сэдвээр илтгэлийг хэлэлцүүлсэн.</p>

		1.6.Их сургууль, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцагсад болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг жил бүр тогтмол зохион байгуулах.	Эрүүл мэндийн сайдын 2013 оны 309 дүгээр тушаалаар 9 дүгээр сарыг “Оюутны эрүүл мэндийг дэмжих сар” болгосонтой холбогдуулан жил бүрийн хичээлийн жил эхлэхэд их, дээд сургуулийн оюутнуудыг сүрьеэ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Хөдөөгийн оюутныг эрүүл мэндийн үзлэгт цаг алдалгүй хамруулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилгоор Эрүүл мэнд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын 2016 оны А/51, А/47, А/136 дугаар тушаалаар Оюутан, суралцагчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн эрүүл мэндийн газарт үүрэг болгож, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жил бүрийн хичээлийн жил эхлэхэд их, дээд сургуулийн оюутнуудыг сүрьеэ, БЗДХ-аас урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулах ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.
4	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 13 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээ 2015.10.01 №28	10. эрүүдэн болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг асуудлын хүрээнд хууль сахиулагчид болон хуульчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хүний эрхийн чиглэлээр тогтмол сургалтад хамруулах	ХЗДХЯам Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор батлагдсан “Нэгдсэн үндэстний байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-ний дагуу хүний эрхийн чиглэлээр Хүний эрхийн үндэсний комисстой хамтран холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион байгуулсан сургалтад хамруулах, зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал: Гадаад харилцааны яамнаас зохион байгуулсан “Олон улсын хүний эрхийн гэрээний тайлан, илтгэл боловсруулах нь” зөвлөгөөн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс зохион явуулсан “Хүний эрхийг хамгаалах”, Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан “Жендэр ба хүний эрх”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ”, “Хуулийн шүүмж”, Хууль зүйн, үндэсний хүрээлэн, “Гал голомт” төрийн бус байгууллагаас хамтран зохион байгуулсан “Хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх нь”, “Жендер, хүний эрх ба хувийн нууц”, Улаан загалмайн нийгэмлэгээс зохион байгуулсан “Жендэр тэгш эрх” сэдэвт сургалтуудад нийт 142 хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хянагч, шийдвэр гүйцэтгэгч болон бусад алба хаагч нарыг хамруулаад байна. Түүнчлэн цагдаагийн байгууллагаас “Хүний эрхийн тухай ойлголт, түгээмэл тунхаглал”, “Хүний эрх ба эрүүдэн шүүхийн эсрэг”, “Зөрчлийг шийдвэрлэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь”, “Эрүү шүүлт тулгах гэмт хэргийг нотлох ажиллагааны онол парктикийн зарим асуудал”, “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийг шалган шийдвэрлэх нь” сэдэвт сургалтуудыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж 61 алба хаагчийг хамруулсан. Мөн эрүү шүүлт тулгах гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл болон эрүүгийн хэргийн дэлгэрэнгүй судалгааг улирал бүр Хүний эрхийн үндэсний комисст хүргүүлэн ажиллаж байна.
Нийт 4 тогтоолын 6 заалтыг хяналтаас хасах саналыг ирүүлсэн байна.			